



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/77

Эрдэнэт

Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.2, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1, 2023 оны захирлын А/96 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны шинжилгээ хийх ажлын хэсэг”-ийн дүгнэлт, Удирдлагын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэр зэргийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын байранд хийсэн шинжилгээний дүгнэлтийг үндэслэн байгууллагын тасгийн эрхлэгч нарын албан тушаалын тодорхойлолтыг нэгдүгээр хавсралтаар, их эмч нарын албан тушаалын тодорхойлолтыг хоёрдугаар хавсралтаар, эм зүйч нарын албан тушаалын тодорхойлолтыг гуравдугаар хавсралтаар, эх баригч нарын албан тушаалын тодорхойлолтыг дөрөвдүгээр хавсралтаар, ахлах сувилагч нарын албан тушаалын тодорхойлолтыг тавдугаар хавсралтаар, сувилагч нарын албан тушаалын тодорхойлолтыг зургаадугаар хавсралтаар, туслах сувилагч нарын албан тушаалын тодорхойлолтыг долоодугаар хавсралтаар, үйлчлэгч албан тушаалын тодорхойлолтыг наймдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан ажлын байрны тодорхойлолтуудыг холбогдох албан тушаалтнуудад танилцуулан шинэчлэн ажиллахыг Хүний нөөцийн албаны дарга (А.Отгон), сувилахуйн албаны дарга (С.Хажидмаа) нарт даалгасугай.

3.Батлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу бүрэн хэрэгжүүлж ажиллахыг эмч, эмнэлгийн ажилтнуудад үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан ажилтан (А.Баярхүү)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ  Ц.НАРАН-ЭРДЭНЭ



612401544  
My doc:/tushaal/A4

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирлын 2024 оны 10 сарын 14 өдрийн А177-тушаалын нэгдүгээр хавсралт



## ТАСГИЙН ЭРХЛЭГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

Дагаж мөрдөх огноо:

2025-01-02

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2024-10-14

Байгууллагын нэр:

Орхон аймаг Бүсийн Оношилгоо  
Эмчилгээний Төв

Нэгжийн нэр:

.....тасаг

Албан тушаалын нэр:

Тасгийн эрхлэгч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮЭМ 7

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Зэст баг,

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн, Хэвийн бус

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Ажлын байрны зорилго	Эмнэлгийн чиг үүргийн хүрээнд ..... тусламж, үйлчилгээг батлагдсан стандарт, удирдамжийн дагуу мэргэжлийн түвшинд үзүүлэх
Ажлын байрны үндсэн зорилт	1. ....эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх 2. Тасгийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдлагаар хангах, хянах үр дүнг мэдээлэх 3. Эрүүл мэндийн даатгалын тогтоолыг мөрдөн ажиллах 4. Чанар сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллах 5. Халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр арга хэмжээ

	<p>авч хэрэгжүүлэн ажиллах</p> <p>6. Сургалт эрдэм шинжилгээний ажилд тасгийн ажилчдыг оролцуулах</p> <p>7. Бусад чиглэлээр</p>		
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр/хувь/
1-р үндсэн зорилтын хүрээнд	<ul style="list-style-type: none"> <li>- Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны MNS 6330:2017 зонхилон тохиолдох өвчин эмгэгийн оношилгоо эмчилгээний удирдамжийг тасагтаа мөрдүүлэх, заавар аргачлалаар хангах</li> <li>- Аймгийн хэмжээнд .....өвчний тусламж үйлчилгээг өргөжүүлэх, бусад нарийн мэргэжлийн эмч нартай хамтран ажиллах.</li> <li>- Хувиарийн дагуу жижүүр эмчид хяналт тавих</li> <li>- Үйлчлүүлэгчийн өвчний талаархи үнэн бодит мэдээллийг үйлчлүүлэгч болон ар гэрт нь энгийн ойлгомтой байдлаар тухай бүр тайлбар өгөх</li> <li>- Шаардлагатай тохиолдолд хэвтэн эмчлүүлэгчийг холбогдох дээд шатлалын эмнэлэгт цаг алдалгүй шилжүүлэх</li> <li>- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй хэм хэмжээг чанд мөрдөж, үйлчлүүлэгч түүний ар гэр, эмнэлгийн ажилтнуудтай эелдэг, хүлээцтэй, харьцан тэдгээрт тулгамдсан асуудлыг тухай бүр нь шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх</li> <li>- Амь тэнссэн үеийн амилуулах тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд стандарт удирдамжийн дагуу багаар үзүүлэх</li> <li>- Олон улсын хөл хориот өвчний голомт, гамшгийн үед дайчлагдан ажиллах эмнэлгийн ажилтныг томилон ажиллуулах ажлыг зохион байгуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Тухайн мэргэжлээрээ үзүүлсэн тусламж үйлчилгээний тоо</li> </ul>	Гүйцэтгэх

<p>2-р үндсэн зорилтын хүрээнд:</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Өдөр бүр тасгийн эрхлэгчийн тойрон үзлэгийг хийж, эмчлэгч эмчийн мэдээллийг сонсож, хэвтэн эмчлүүлэгчдэд тухайн өдөр хийх эмчилгээ үйлчилгээг төлөвлөн, хяналт тавин ажиллах</li> <li>- Эмч нарын хамтарсан үзлэг, эмчилгээ сувилгааны чанарын хурал, хэлэлцүүлгийг тасагтаа зохион байгуулах</li> <li>- Сар болгон онцгой тохиолдолуудыг тасагтаа хэлэлцэн, дүгнэх</li> <li>- Тасгийн эмч, сувилагч нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэхэд анхаарч, судалгаа шинжилгээний ажлыг хамтран хийх</li> <li>- Мансууруулах сэтгэц нөлөөт эмийн шүүгээн дэх эмийн байдал, зарцуулалт, хадгалалт, бичиг баримтын бүрдэлтэнд тогтмол хяналт тавих</li> <li>- Тасгийн ажилчдын ажлын хариуцлага, харилцаа хандлага, цаг ашиглалт, хувцаслалтанд хяналт тавиж, хариуцлага тооцон ажиллах</li> <li>- Эмнэлэг үйлчилгээний болон ёс зүйн харьцаа хандлагын зөрчилгүй ажиллаж бусдыгаа манлайлан ажилласан ажилчдыг ЭМЯ болон аймаг орон нутаг, төрийн одон медалиар шагнуулахаар тодорхойлон хүний нөөцийн албанд хүргүүлэх</li> <li>- Байгууллагын удирдлага, эрүүл мэндийн газар, аймаг бусад холбогдох газраас өгсөн үүрэг даалгаварыг заасан хугацаанд биелүүлэх, мэдээллийг тухай бүр тасгийн эмч, ажилчдад мэдээллэх</li> <li>- Тасгийн эм эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдал, хадгалалт хэрэглээнд хяналт тавих, доголдол гарсан тухай бүрд нь холбогдох албан тушаалтанд танилцуулж шийдвэрлүүлэх</li> <li>- Тасагт хөтлөгддөг анхан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Тасгийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан</li> <li>- Авсан арга хэмжээ</li> </ul>	<p>Хянах</p>
-------------------------------------	---	--	--------------

	<p>шатны бичиг баримт, өвчний түүхийн хөтлөлт, бусад бичиг баримтын хөтлөлтөнд хяналт тавиж, мэдээ тайланг тухай бүр нь гарган өгөх</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тасагт ашиглагддаг багаж тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал ашиглалтанд хяналт тавин ажиллах.</li> <li>- Эмч сувилагч нарын ажлын уялдаа холбоог хангаж, ажил үүргийн хуваарийг мөрдүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэн ажиллуулах саналыг удирдлагын зөвлөлд хүргүүлэн шийдвэрлүүлэх</li> </ul>		
<p>3-р үндсэн зорилтын хүрээнд:</p>	<ul style="list-style-type: none"> <li>- ЭМДҮЗ-н хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тушаал журам, тогтоол шийдвэрийг хангаж ажиллах</li> <li>- Байгууллагын ЭМДЕГ-тай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах</li> <li>- Үзүүлсэн тусламж үйлчилгээнд тавигдах ЭМДЕГ-н хяналтад идэвхи санаачлагатай ажиллаж, заасан хугацаанд шаардлагатай материалыг бүрэн хүлээлгэж өгөх</li> <li>- Тасгийн эмч нарын өвчний түүхийг тухай бүр нь шалган хааж гарын үсэг зурж баталгаажуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн даатгалаас авсан санхүүжилтын хувь,</li> <li>- Санхүүжилтын алдагдалын хувь</li> <li>- Гэрээлсэн тусламж үйлчилгээний тоо</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Гүйцэтгэх</li> <li>- Хянах</li> </ul>

<p>4-р үндсэн зорилтын хүрээнд:</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Тасгийнхаа чанарын багийг ахлаж, чанарын багийн төлөвлөөг ЭМТҮЧАБ-ын албаар батлуулан хэрэгжилтэнд хяналт тавин биелэлтийг улирал тутам гаргаж ажиллах</li> <li>- Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой тохиолдол бүртгэх, мэдээлэх журамд заасны дагуу хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг өөрийн удирдаж буй тасаг нэгж дээр гардан хэрэгжүүлж, дахин давтагдахаас сэргийлэх, бууруулах арга хэмжээ авах</li> <li>- Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой тохиолдол бусад тасаг нэгжид тохиолдох, эрсдлээс сэргийлэх үүднээс мэдээлэл, туршлагаа хуваалцах үйл ажиллагааг байгууллагын чанар аюулгүй байдлын албатай хамтран хэрэгжүүлнэ.</li> <li>- Өөрийн хариуцсан нэгжийн хүрээнд өртөж болзошгүй эрсдэлийг бүртгэн мэдээлж, эрсдэлийн үнэлгээ хийн арилгах, бууруулах арга хэмжээг эрсдэл аюулгүй байдал хариуцсан менежиртэй хамтран төлөвлөж хэрэгжүүлнэ.</li> <li>- Хариуцсан тасаг нэгжид хэрэгжүүлж чадах эрх мэдлээс хэтэрсэн удирдах боломжгүй эрсдэлийн талаар эрсдэлийн баг, удирдлагад шуурхай мэдээлнэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эрсдлээс сэргийлэх төлөвлөгөө, биелэлт</li> <li>- Бүртгэгдсэн эрсдэлийн тоо авсан арга хэмжээ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Гүйцэтгэх</li> <li>- Хянах</li> </ul>
<p>5-р үндсэн зорилтын хүрээнд:</p>	<ul style="list-style-type: none"> <li>- ЭМС-ын 2019 оны А/539 тоот тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг илрүүлэх, тандахад хяналт тавин мэдээлэх арга хэмжээ авах</li> <li>- Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд анхааран ажиллаж, улирал тутам нян судлаач эмчийн гаргаж өгсөн антибиогарммыг мөрдүүлэхд</li> </ul>		

	<p>тасгийн эмч нарт хяналт тавин ажиллах</p> <ul style="list-style-type: none"> <li>- ЭТҮХХ-тэй холбоотой тандалтыг үйлчлүүлэгчиддээ өдөр бүр хийж сэжигтэй илэрсэн тохиолдлыг тухай бүр халдвар судлаачид мэдээлж байх</li> <li>- ЭТҮХХ-той өртөлтийн тохиолдолийг халдавр судлаач эмч болон чанарын албанд тухай бүр мэдээлэх, хариу арга хэмжээ авах</li> <li>- Халдварт өвчний дэгдэлтийн үед хэрэглэгдэх өмсгөл, халдваргүйжүүлэх уусмал, эм тарианы бэлэн байдалд хяналт тавиж тасралтгүй байдлыг ханган ажиллах.</li> <li>- Үйлчлүүлэгчийг ЭТҮХХ-той халдвараас сэргийлэхтэй холбогдуулан сувилахуйн тусламжийн үйлдэлд хяналт тавих</li> </ul>		
<p>6-р үндсэн зорилтын хүрээнд:</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Эмч сувилагчдын сургалтын хэрэгцээний талаар санал боловсруулах, төгсөлтийн дараахь мэрэгжил дээшлүүлэх, мэрэгшүүлэх богино урт хугацааны сургалтанд эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан мэдлэг боловсролыг нь байнга дээшлүүлэх</li> <li>- Үйлчлүүлэгчдэд үзүүлж буй тусламж, үйлчилгээний талаар эмч, сувилагч нарт мэргэжил арга зүйн дэмжлэг байнга үзүүлэх</li> <li>- Ажлын байран дах тасралтгүй сургалтын багц цагийн хөтөлбөрт эмч эмнэлгийн ажилчдыг тогтмол хамруулах</li> <li>- Нотолгоонд суурилсан эрдэм шинжилгээ судалгаа, онол практикийн хуралд илтгэл хэлэлцүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх</li> <li>- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаанд ажилчдыг хамруулах мэдээллээр хангах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Давтан сургалтанд хамрагдсан тоо</li> <li>- Бүрдүүлсэн багц цагийн биелэлт</li> <li>- Эрдэм шинжилгээ судалгаа, ОПБХ-д оролцсон тоо</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Гүйцэтгэх</li> <li>- Хянах</li> </ul>

7-р үндсэн зорилтын хүрээнд:	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүй хэм хэмжээг чанд мөрдөж, үйлчлүүлэгч түүний ар гэр, эмнэлгийн ажилтнуудтай эелдэг, хүлээцтэй, харьцан тэдгээрт тулгамдсан асуудлыг тухай бүр нь шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.</li> <li>- Авилагын эсрэг хууль, тогтоомжийг судлаж, авилагаас ангид байх тал дээр анхааран ажиллах</li> <li>- Байгууллагын дотоод журмын хэрэгжилтийг хангаж, холбогдох журмын дагуу ажлаа тайлагнаж үнэлүүлэх</li> <li>- Монгол улсын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль, эмнэлгийн дотоод журам, бусад холбогдох зүйл, заалтуудыг мөрдөн ажиллах</li> <li>- “Эүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандарт, ЭМС-ын сайдын 2015 оны 189 дугаар тушаал, “Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажлын байранд мөрдөх нийтлэг журам”-ын дагуу ажлын хувцасыг тогтмол өмсөх,</li> <li>- Ажлын байран дээр хувийн хамгаалах хэрэгслийг байнга хэрэглэх,</li> <li>- Галын аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавин ажиллах</li> <li>- “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”-ийг чанд мөрдөн ажиллаах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Холбодох хууль тогтоомжуудтай танилцсан ажилтны тоо</li> <li>- Ёс зүйн зөрчил гаргасан тоо, авсан арга хэмжээ</li> </ul>	Гүйцэтгэх
------------------------------	--	---	-----------

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА:

Ерөнхий шаардлага	Боловсрол	Анагаах ухааны их дээд сургуулийг хүний их эмчийн бакалавар, дипломтой төгссөн байх
	Мэргэжил	<ul style="list-style-type: none"> <li>- Тухайн чиглэлээрээ мэргэшсэн байх</li> <li>- Боловсролын магистер хамгаалсан бол давуу</li> <li>- Мэргэшлийн зэрэгтэй бол давуу</li> </ul>
	Туршлага	Тодорхой нэг байгууллагад нэгжийн менежерээр ажиллаж байсан бол давуу

	Ур чадвар	<ul style="list-style-type: none"> <li>- Харилцааны өндөр соёлтой</li> <li>- Багаар ажиллах</li> <li>- Үүрэг харицлага хүлээх</li> <li>- Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах</li> <li>- Комьютерийн өргөн хэрэглээний программ дээр ажиллах</li> <li>- Гадаад хэлний зохих мэдлэгтэй байх</li> <li>- Ачаалал даах чадвартай</li> </ul>
	Эрүүл мэнд	Эрүүл мэндийн үзлэгээр бие болон сэтгэцийн хувьд эрүүл , тэнцсэ дүгнэлттэй.

Тусгай шаардлага	“Эмчлэх ” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй
Орлон ба хавсарч ажиллах ажлын байрны нэр	Ажлын шаардлагаар болон цуг ажилладаг их эмчийг амарсан, өвчтэй, чөлөөтэй үед орлох буюу хавсран ажиллах.

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:	“БОЭТ”-ын удирдлага
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	<b>Бусад харилцах субъект :</b> <ul style="list-style-type: none"> <li>- Тасгийн их эмч, сувилагч, үйлчлэгч</li> <li>- Эмнэлгийн бусад ажилтан</li> </ul>

#### V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
<b>Албан тушаал:</b> ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ ДАРГА ..... А.ОТГОН (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20... оны ..... дугаар сарын .....-ны өдөр	<b>Байгууллагын нэр:</b> ОРХОН АЙМГИЙН БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНЫ ТӨВ  <b>Шийдвэрийн огноо:</b> 20.....-01.....  <b>Дугаар:</b> .....

#### АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН

<b>Байгууллагын нэр:</b> БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНЫ ТӨВИЙН ЗАХИРАЛ  .....Ц.НАРАН-ЭРДЭНЭ (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)	<b>Тасгийн нэр:</b> ЭМЧИЛГЭЭ ЭРХЭЛСЭН ОРЛОГЧ ЗАХИРАЛ  .....М.АЛТАНБЕК (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20... оны ... дугаар сарын ... -ны өдөр
--	--

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

**АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТТОЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН**

“.....”-ИЙН ТАСГИЙН ЭРХЛЭГЧ ...../...../

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр



## ИХ ЭМЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Төрийн албаны зөвлөлийн  
2019 оны 03 дугаар тогтоолын 2 дугаар  
хавсралт

Дагаж мөрдөх огноо:

2025-01-02

Албан тушаалын тодорхойлолтыг  
баталсан огноо:

2024-10-14

Байгууллагын нэр:

Орхон аймаг Бүсийн Оношилгоо  
Эмчилгээний Төв

Нэгжийн нэр:

..... тасаг

Албан тушаалын нэр:

..... их эмч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮЭМ 7(ТҮЭМ 6, ТҮЭМ5)

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Зэст баг,  
Хантайн гудамж

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн, Хэвийн бус

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Ажлын байрны зорилго	Эмнэлгийн чиг үүргийн хүрээнд гэмтэл согог заслын өвчний тусламж, үйлчилгээг батлагдсан стандарт, удирдамжийн дагуу мэргэжлийн түвшинд үзүүлэх
Ажлын байрны үндсэн зорилт	<ol style="list-style-type: none"><li>..... эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх</li><li>Эрүүл мэндийн даатгалын тогтоолыг мөрдөн ажиллах</li><li>Чанар сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллах</li><li>Халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллах</li><li>Сургалт эрдэм шинжилгээний ажил</li><li>Бусад чиглэлээр</li></ol>

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр
1-р үндсэн зорилтын хүрээнд	<ul style="list-style-type: none"> <li>- Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны MNS 6330:2017 болон тухайн чиглэлээр зонхилон тохиолдох өвчин эмгэгийн оношилгоо эмчилгээний удирдамжийн дагуу үзлэг, оношилгоо хийж, эмчлэх</li> <li>- Аймгийн хэмжээнд тухайн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, хагалгааны нэр төрлийг нэмэгдүүлэх тал дээр идэвх санаачлага гарган ажиллах</li> <li>- ЭМС-ийн 611 дугаар тушаалын дагуу тасагт хөтлөгдөж байгаа анхан шатны бичиг баримт, өвчний түүхийн хөтлөлт, бусад бичиг баримтыг хөтлөн, мэдээ тайланг тухай бүр нь гарган өгөх</li> <li>- Үйлчлүүлэгчид болон ар гэрт нь өвчний талаархи үнэн бодит мэдээллийг энгийн ойлгомтой байдлаар тухай бүр тайлбарлаж өгөх</li> <li>- Шаардлагатай тохиолдолд хэвтэн эмчлүүлэгчийг холбогдох дээд шатлалын эмнэлэгт цаг алдалгүй шилжүүлэх</li> <li>- Амь тэнссэн үеийн амилуулах тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд стандарт удирдамжийн дагуу үзүүлэх</li> <li>- Олон улсын хөл хориот өвчний голомт, гамшгийн үед дайчлагдан ажиллах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хийсэн оношилгоо, эмчилгээний тусламж үйлчилгээний тоо</li> </ul>	Гүйцэтгэх
2-р үндсэн зорилтын хүрээнд	<ul style="list-style-type: none"> <li>- ЭМДҮЗ-н хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тушаал журам, тогтоол шийдвэрийг хангаж ажиллах</li> <li>- Байгууллагын ЭМДЕГ-тай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах</li> <li>- Үзүүлсэн тусламж үйлчилгээнд тавигдах ЭМДЕГ-н хяналтад идэвхи санаачлагатай ажиллаж, заасан хугацаанд шаардлагатай материалыг бүрэн хүлээлгэж өгөх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн даатгалаас авсан санхүүжилтын хувь,</li> <li>- Санхүүжилтын алдагдалын хувь</li> </ul>	Гүйцэтгэх
3-р үндсэн зорилтын хүрээнд	<ul style="list-style-type: none"> <li>- JCI-ийн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын стандартыг хэрэгжүүлэн ажилын байранд IPSPG 6 дүрмийг баримтлаж ажиллах</li> <li>- Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой тохиолдол бусад тасаг нэгжид тохиолдох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бүртгэгдсэн эрсдэлийн тоо</li> </ul>	Гүйцэтгэх

	<p>эрсдлээс сэргийлэх үүднээс мэдээлэл, туршлагаа хуваалцах үйл ажиллагааг байгууллагын чанар аюулгүй байдлын албатай хамтран ажиллах</p> <ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн хариуцсан нэгжийн хүрээнд өртөж болзошгүй эрсдэлийг бүртгэн мэдээлж, эрсдэлийн үнэлгээ хийн арилгах, бууруулах арга хэмжээг эрсдэл аюулгүй байдал хариуцсан менежиртэй хамтран төлөвлөж хэрэгжүүлнэ.</li> <li>- Техник технологийн болон аюулгүй ажиллагааны горим зөрчигдсөн тохиолдолд холбогдох мэргэжилтнүүдэд мэдэгдэж яаралтай арга хэмжээ авч засаж залруулах арга хэмжээ авах.</li> <li>- Хариуцсан тасаг нэгжид хэрэгжүүлж чадах эрх мэдлээс хэтэрсэн удирдах боломжгүй эрсдэлийн талаах эрсдэлийн баг, удирдлагад шуурхай мэдээлэх</li> </ul>		
<p>4-р үндсэн зорилтын хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- ЭМС-ын 2019 оны А/539 тоот тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг илрүүлэх, тандахад хяналт тавин мэдээлэх арга хэмжээ авах</li> <li>- Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд анхааран ажиллаж, улирал тутам нян судлаачийн гарган өгдөг антибиогарммыг мөрдөн ажиллах</li> <li>- ЭТҮХХ-тэй холбоотой тандалтыг үйлчлүүлэгчиддээ өдөр бүр хийж сэжигтэй илэрсэн тохиолдолыг тухай бүр тасгийн эрхлэгч, халдвар судлаачид мэдээлж байх</li> <li>- ЭТҮХХ-той өртөлтийн тохиолдолийг тухай бүр мэдээлэх, хариу арга хэмжээ авах</li> <li>- Үйлчлүүлэгчээ ЭТҮХХ-той халдвараас сэргийлэхтэй холбогдуулан сувिलाхуйн тусламжийн үйлдэлд хяналт тавих</li> </ul>	<p>Халдварын сэргийлэлт хяналтаар илрүүлсэн зөрчил, авсан арга хэмжээ</p>	<p>Гүйцэтгэх</p>

<p>5-р үндсэн зорилтын хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлчлүүлэгчдэд эрүүл аж төрөх ёс, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, зөвлөгөөг тогтмол өгөх,</li> <li>- Эрүүл мэндийн яам, эрүүл мэндийн хөгжлийн төв, мэргэжлийн албар салбар нийгэмлэг, эрүүл мэндийн газар, байгуулагаас зохион явуулж байгаа ёс зүйн болон мэргэжлийн тасралтгүй сургалтуудад байнга хамрагдан багц цагийг жил бүр бүрдүүлэн ажиллах</li> <li>- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдах</li> <li>- Тасгийн эмч, сувилагч нарт мэргэжил арга зүйн дэмжлэг байнга үзүүлэж, сургалт зохион байгуулах</li> <li>- Нотолгоонд суурилсан эрдэм шинжилгээ судалгаа, онол практикийн хуралын илтгэл хэлэлцүүлэгт оролцох</li> <li>- Компьютерийн хэрэглээний програмууд болон гадаад хэлний мэдлэгээ байнга сайжруулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сургалтанд хамрагдсан тоо</li> <li>- Эрдэм шинжилгээ судалгаа, ОПБХ-д оролцсон тоо</li> </ul>	<p>Гүйцэтгэх</p>
<p>6-р үндсэн зорилтын хүрээнд:</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүй хэм хэмжээг чанд мөрдөж, үйлчлүүлэгч түүний ар гэр, эмнэлгийн ажилтнуудтай эелдэг, хүлээцтэй, харьцан тэдгээрт тулгамдсан асуудлыг тухай бүр нь шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.</li> <li>- Авилагын эсрэг хууль, тогтоомжийг судлаж, авилагаас ангид байх тал дээр анхааран ажиллах</li> <li>- Байгууллагын дотоод журмын хэрэгжилтийг хангаж, холбогдох журмын дагуу ажлаа тайлагнаж үнэлүүлэх</li> <li>- Монгол улсын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль, эмнэлгийн дотоод журам, бусад холбогдох зүйл, заалтуудыг мөрдөн ажиллах</li> <li>- “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандарт, ЭМС-ын сайдын 2015 оны 189 дугаар тушаал, “Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажлын байранд мөрдөх нийтлэг журам”-ын дагуу ажлын хувцасыг тогтмол өмсөх,</li> <li>- Ажлын байран дээр хувийн хамгаалах хэрэгслийг байнга</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын гүйцэтгэл,</li> </ul>	<p>Гүйцэтгэх</p>

	<p>хэрэглэх,  - Галын аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавин ажиллах  - “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”-ийг чанд мөрдөн ажиллах</p>		
<b>III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА:</b>			
Ерөнхий шаардлага	Боловсрол	Ангаах ухааны их дээд сургуулийг хүний их эмчээр бакалавр. дипломтой төгссөн	
	Мэргэжил	..... судлалын их эмч ( мэргэжлийн код)	
	Мэргэшил	Тухайн чиглэлээр үндсэн мэргэшлийн сургалтанд хамрагдсан байх	
	Туршлага	Тодорхой байгууллагад 6 сараас дээш ажилласан бол давуу	
	Ур чадвар	<ul style="list-style-type: none"> <li>- Харилцааны өндөр соёлтой</li> <li>- Багаар ажиллах</li> <li>- Үүрэг харицлага хүлээх</li> <li>- Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах</li> <li>- Комьютерийн өргөн хэрэглээний программ дээр ажиллах</li> <li>- Гадаад хэлний зохих мэдлэгтэй байх</li> <li>- Ачаалал даах чадвартай</li> </ul>	
	Эрүүл мэнд	Эрүүл мэндийн үзлэгээр бие болон сэтгэцийн хувьд эрүүл , тэнцсэн дүгнэлттэй.	
Тусгай шаардлага	“Эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй		
Орлон ба хавсарч ажиллах ажлын байрны нэр	Ажлын шаардлагаар болон цуг ажилладаг тасгийн болон амбулаторийн их эмчийг амарсан, өвчтэй, чөлөөтэй үед орлох буюу хавсран ажиллах.		
<b>IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ</b>			
<u>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</u>		Тасгийн эрхлэгч	
<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>		Бусад харилцах субъект : <ul style="list-style-type: none"> <li>- Тасгийн их эмч, сувилагч, үйлчлэгч</li> <li>- Эмнэлгийн бусад ажилтан</li> </ul>	
<b>V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ</b>			
<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>		<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>	

<p><u>Албан тушаал:</u>  ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ ДАРГА  ..... А.ОТГОН  (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)  20... оны ..... дугаар сарын .....-ны өдөр</p>	<p><u>Байгууллагын нэр:</u>  ОРХОН АЙМГИЙН БҮСИЙН  ОНОШИЛГОО  ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ  <u>Шийдвэрийн огноо:</u> 20... он ....сар  .....өдөр  <u>Дугаар:</u> Б/.....</p>
<p>БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ  ТӨВИЙН ЗАХИРАЛ  .....Ц.НАРАН-ЭРДЭНЭ  (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн  нэр)  20... оны .... дугаар сарын ... -ны өдөр</p>	<p>..... ТАСГИЙН ЭРХЛЭГЧ:  ...../АЖИЛТНЫ НЭР/  (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн  нэр)  20... оны ... дугаар сарын ... -ны өдөр</p>
<b>VII. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТТОЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН</b>	
<p>..... ТАСГИЙН ИХ ЭМЧ ...../АЖИЛТНЫ НЭР/  20... оны ... дугаар сарын ... -ны өдөр</p>	

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн  
захирлын 2024 оны 10 сарын 14 өдрийн А/77  
тушаалын гуравдугаар хавсралт

ЭМ ЗҮЙЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

<input checked="" type="checkbox"/> Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан	
<input type="checkbox"/> Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон	
Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт
Дагаж мөрдөх огноо:	2025-01-02
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:	2024-10-14
Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Орхон аймаг "Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төв"	Эм зүйн тасаг
Албан тушаалын нэр:	Албан тушаалын ангилал, зэрэглэл:
Эм зүйч	ТҮЭМ 5
Ажлын цаг:	Ажлын байрны албан ёсны байршил:
Ажлын өдөр 8 цаг	Орхон аймаг, Баян-Өндөр сум, Зэст баг, Хантайн гудамж
Хөдөлмөрийн нөхцөл:	Онцгой нөхцөл:
Хэвийн, Хэвийн бус	Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Ажлын байрны зорилго	Байгууллага, алба нэгжийн чиг үүргийн хүрээнд эмзүйн тусламж, үйлчилгээг батлагдсан стандарт удирдамжийн дагуу мэргэжлийн түвшинд үзүүлэх		
Ажлын байрны үндсэн зорилт	1. Эмнэлгийн эмзүйн тусламж, үйлчилгээг үзүүлэх 2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх 3. Сургалт, эрдэм шинжилгээний ажилд оролцох 4. Бусад үйл ажиллагаанд оролцох		
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр

<p>1-р үндсэн зорилтын хүрээнд</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Тухайн хариуцсан тасаг нэгжид эмзүйн тусламж үйлчилгээг эм зүйн технологи, стандартыг мөрдөн ажилах</li> <li>- Тасгийн эмийн анхан шатны мэдээ, бүртгэл маягтыг зохих журмын дагуу хөтөлсөн эсэх олон зарцуулалтанд хяналт тавин ажиллах</li> <li>- Сүрьегийн болон ХДХВ-ын эмчилгээний эм тарианы найруулах үйл ажиллагаа болон сүрьегийн эмчилгээг сар бүр хянаж тайлан мэдээ гаргах,</li> <li>- Тасгийн эмийн захиалганд хяналт тавин ажиллах</li> <li>- Тасгийн эм олгох түгээх, хадгалах, найруулах үйл ажиллагаанд хяналт тавих</li> </ul>	<p>Үйл ажиллагааны тайлан</p>	<p>Гүйцэтгэх</p>
<p>2-р үндсэн зорилтын хүрээнд:</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хэвтэн эмчлүүлэгчдэд эмийн зөв зохистой хэрэглээний талаархи эрүүл мэндийн сургалт зохион байгуулах</li> <li>- Шинэ эмний мэдээллийг тухай бүр тасагтаа мэдээлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Үйл ажиллагаанд оролцсон байдал</li> <li>- Сургалтанд оролцсон байдал</li> </ul>	<p>Гүйцэтгэх</p>
<p>3-р үндсэн зорилтын хүрээнд:</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлчлүүлэгчдэд эрүүл аж төрөх ёс, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, зөвлөгөөг тогтмол өгөх,</li> <li>- Эрүүл мэндийн яам, эрүүл мэндийн хөгжлийн төв, мэргэжлийн албар салбар нийгэмлэг, эрүүл мэндийн газар, байгуулагаас зохион явуулж байгаа ёс зүйн болон мэргэжлийн тасралтгүй сургалтуудад байнга хамрагдан багц цагийг жил бүр бүрдүүлэн ажиллах</li> <li>- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдах</li> <li>- Тасгийн эмч, сувилагч нарт мэргэжил арга зүйн дэмжлэг байнга үзүүлэж, сургалт зохион байгуулах</li> <li>- Нотолгоонд суурилсан эрдэм шинжилгээ судалгаа, онол практикийн хуралын илтгэл хэлэлцүүлэгт оролцох</li> <li>- Компьютерийн хэрэглээний программууд болон гадаад хэлний мэдлэгээ байнга</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сургалтанд хамрагдсан тоо</li> <li>- Эрдэм шинжилгээ судалгаа, ОПБХ-д оролцсон тоо</li> </ul>	<p>Гүйцэтгэх</p>

	сайжруулах		
4-р үндсэн зорилтын хүрээнд:	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүй хэм хэмжээг чанд мөрдөж, үйлчлүүлэгч түүний ар гэр, эмнэлгийн ажилтнуудтай эелдэг, хүлээцтэй, харьцан тэдгээрт тулгамдсан асуудлыг тухай бүр нь шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.</li> <li>- Авилагын эсрэг хууль, тогтоомжийг судлаж, авилагаас ангид байх тал дээр анхааран ажиллах</li> <li>- Байгууллагын дотоод журмын хэрэгжилтийг хангаж, холбогдох журмын дагуу ажлаа тайлагнаж үнэлүүлэх</li> <li>- Монгол улсын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль, эмнэлгийн дотоод журам, бусад холбогдох зүйл, заалтуудыг мөрдөн ажиллах</li> <li>- “Эүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандарт, ЭМС-ын сайдын 2015 оны 189 дугаар тушаал, “Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажлын байранд мөрдөх нийтлэг журам”-ын дагуу ажлын хувцасыг тогтмол өмсөх,</li> <li>- Ажлын байран дээр хувийн хамгаалах хэрэгслийг байнга хэрэглэх,</li> <li>- Галын аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавин ажиллах</li> </ul> <p>“Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”-ийг чанд мөрдөн ажиллах</p>	- Ажлын гүйцэтгэл,	Гүйцэтгэх

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА:

Ерөнхий шаардлага	Боловсрол	Ангаах ухааны их дээд сургуулийг эм зүйч мэргэжлээр бакалавр, дипломтой төгссөн
	Мэргэжил	Эм зүйч ( мэргэжлийн код)
	Туршлага	Тодорхой байгууллагад 6 сараас дээш ажилласан бол давуу
	Ур чадвар	<ul style="list-style-type: none"> <li>- Харилцааны өндөр соёлтой</li> <li>- Багаар ажиллах</li> <li>- Үүрэг харицлага хүлээх</li> <li>- Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах</li> <li>- Комьютерийн өргөн хэрэглээний программ дээр ажиллах</li> <li>- Гадаад хэлний зохих мэдлэгтэй байх</li> <li>- Ачаалал даах чадвартай</li> </ul>

	Эрүүл мэнд	Эрүүл мэндийн үзлэгээр бие болон сэтгэцийн хувьд эрүүл, тэнцсэн дүгнэлттэй.
Тусгай шаардлага	“Эм барих” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй	
Орлон ба хавсарч ажиллах ажлын байрны нэр	Ажлын шаардлагаар болон цуг ажилладаг эм зүйчийг амарсан, өвчтэй, чөлөөтэй үед орлох буюу хавсран ажиллах.	
<b>IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ</b>		
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:	БОЭТ-н захирал, Эмнэл зүйн эрхэлсэн дэд захирал, албадын дарга нар, тасгийн эрхлэгч	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо	Бусад харилцах субъект: Тасгийн эрхлэгч, эмч, эм зүйч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн	
<b>V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ</b>		
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:	
Албан тушаал: ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ ДАРГА ..... А.ОТГОН (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20... оны ... сарын...-ны өдөр	Байгууллагын нэр: ОРХОН АЙМАГ БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНЫ ТӨВ  Шийдвэрийн огноо: 202...оны ... сарын .... өдөр Дугаар: .....	
<b>АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН</b>		
Байгууллагын нэр: БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНЫ ТӨВИЙН ЗАХИРАЛ .....Ц.НАРАН-ЭРДЭНЭ (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20.... оны .... дугаар сарын ... -ны өдөр	Тасгийн нэр: ЭМ ЗҮЙН ТАСГИЙН ЭРХЛЭГЧ .....(тасгийн эрхлэгчийн нар) (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 202... оны ... сарын .....-ны өдөр	
<b>АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТТОЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН</b>		
ЭМ ЗҮЙЧ .....(Эм зүйчийн нэр) 202 ...оны..... сарын .....-ны өдөр		

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн  
захирлын 2024 оны 10 сарын 14 өдрийн  
А177 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

6117143521 д. 9043322

## ЭХ БАРИГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
шинэчлэн боловсруулсан  
Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Төрийн албаны зөвлөлийн 2019 оны  
03 дугаартай тогтоол  
Дагаж мөрдөх огноо: 2025 оны 01 сарын 02 өдрөөс  
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2024 оны 10 сарын 14 өдөр

Байгууллагын нэр:

Бүсийн оношилгоо эмчилгээний төв

Нэгжийн нэр:

Төрөх, төрсний дараах тасаг, эрсдэлтэй  
жирэмсний тусламжийн тасаг, хүлээн авах,  
өртөмгий бүлгийн жирэмсний үзлэгийн  
хэсэг

Албан тушаалын нэр:

Эх баригч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮЭМ-5

Ажлын цаг:

8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Зэст баг,  
Хантайн гудамж 1

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

#### Албан тушаалын зорилго:

Байгууллага, тасгийн дотоод дүрэм, журмыг баримтлан эх, хүүхэд, эмэгтэйчүүд, нөхөн  
үржихүйн чиглэлээр эх барихуй, сувилахуйн тусламж, үйлчилгээг чанартай, тэгш,  
хүртээмжтэй үзүүлэх.

#### Албан тушаалын зорилт:

1. Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх
2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагын хэм хэмжээ баримтлах
3. Үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох, дэмжих чиглэлээр үйл  
ажиллагаанд оролцох
4. Амь тэнссэн, яаралтай тусламж шаардагдсан осол гэмтэл, байгалийн болон нийтийг  
хамарсан гамшиг, шинэ болон сэргэн тархаж байгаа халдварын үед эрүүл мэндийн  
тусламж, үйлчилгээ үзүүлэх
5. Мэдлэг, мэргэшил, ур чадвараа тогтмол дээшлүүлэх, судалгааны ажил хийх,  
мэргэжлийн чиглэлээр эрүүл мэндийн ажилтнуудад сургалт явуулах, анхан шатны  
бүртгэл маягтыг хөтлөх

6. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж, эх барихуйн тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагаанд оролцох
7. Бусад үйл ажиллагаанд оролцох

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр
<p><b>1 дүгээр зорилтын хүрээнд:</b></p> <p>Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх</p>	Эх барихын тусламж, үйлчилгээг жирэмсэн, төрөх, төрсний дараах үед эх, ураг, нярайд батлагдсан журам заавар, стандартын дагуу үзүүлэх	Стандартын хэрэгжилтийн хувь	Т,Г
	Үйлчлүүлэгчийн эрх, ашиг, сонголт, сэтгэл зүй, соёл, зан заншлыг хүндэтгэсэн, үйлчлүүлэгч, түүний хамтрагч, гэр бүлийн шийдвэр гаргалтыг дэмжсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх	Ажлын тайлан	Т,Г
	Хэвийн явцтай жирэмсэн эмэгтэйг хянах, ургийн өсөлт хөгжил, ургийн зурхний үйл ажиллагааг (стетоскопоор, ургийн бичлэг) хянан өөрчлөлт илэрсэн тохиолдолд эмчид илгээх.	Ажлын тайлан	Г,Х
	Жирэмсэн эмэгтэй, түүний хамтрагч, гэр бүлийнхэнд нотолгоонд суурилсан мэдээлэл, зөвлөгөө өгөх;	Ажлын тайлан, зөвлөгөө, мэдээлэл өгсөн тоо	Г
	Хэвийн явцтай жирэмсэн эмэгтэйн төрөлтийг эмчтэй хамтран багаар удирдаж, төрөлтийн явцад партограммыг бүрэн хөтөлж хянах	Ажлын тайлан	Т,Г,Ш
	Төрөлтийн явцад эх, урагт эмгэг өөрчлөлт илэрвэл анхан шатны яаралтай тусламжийг үзүүлж, эмчид нэн даруй яаралтай мэдээллэж багаар тусламж үзүүлэх	Эх барихын яаралтай тусламж үзүүлсэн тоо	Т,Г
	Төрсний дараах эрт үед эхийг төрөх өрөөнд хянаж, төрсний дараах тасагт шилжүүлэх	Ажлын тайлан, хянасан эхийн тоо	Г,Х
	Төрсөн нярайд үнэлж, нярайн эрт үеийн нэн шаардлагатай НЭҮНШТ тусламж үзүүлэх.	Тусламж үзүүлсэн тоо	Г
	Бүтэлттэй төрсөн нярайд сэхээн амьдруулах тусламжийг яаралтай үзүүлж, нярайн эмч эсвэл их	Нярайд сэхээн амьдруулалт үзүүлсэн тоо	Т,Г

	эмчийг дуудан тусламжийг багаа үзүүлэх;		
	Төрсөн эхэд зөвлөгөө хөхөөр хооллолт, эрүүл ахуй, халдвар хамгаалал,хооллолт, дасгал хөдөлгөөн, төрсний дараах сэтгэлзүй зөвлөгөө өгөх	Ажлын тайлан, зөвлөгөө өгсөн эхийн тоо	Г,Х
	Сургалтад сурч гэрчилгээ авсан эх баригч умайн хөндийд ерөндөг тавих	Ажилбарын тоо	Г
<b>2 дугаар зорилтын хүрээнд:</b>  Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагын хэм хэмжээ баримтлах	Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчтэй харилцах, эмнэлгийн мэргэжилтэн хоорондын харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээг баримтлах буюу сайдын тушаалыг мөрдөн ажиллах.	Тохиолдлын тоо	Г
	Үйлчилгээний соёлыг мөрдөж сэтгэл ханамжийг сайжруулж гомдол, саналгүй ажиллах	Гомдол, саналын тоо	Г
	Тусламж үйлчилгээтэй холбоотой үйлдэгдсэн баримт бичгийг хуурамчаар үйлдэх, засварлахгүй, цааш тараах, дамжуулахгүй байх	Тохиолдлын тоо	Г
	Үйлчлүүлэгчдэд хүнлэг, энэрэнгүй, хүндэтгэлтэй хандах, хүн бүрт тэгш хандаж, үйлчлүүлэгчид хүндэтгэлтэй, хүний эрхийг дээдэлсэн тусламж, үйлчилгээг үзүүлэх	Тохиолдлын тоо	Г
	Ашиг сонирхлын үүднээс төлбөр авах, өөр эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлэхийг албадах, санал болгох, авилга авах, шаардлагагүй тусламж үйлчилгээг зааварчлах, үйлчлүүлэгчийн өмнөөс сонголт хийхгүй байх	Тохиолдлын тоо	Г
<b>3 дугаар зорилтын хүрээнд:</b>  Үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох, дэмжих чиглэлээр үйл ажиллагаанд оролцох	Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, бэлгийн замаар дамжих халдвар, жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийг сонгох, хэрэглэх талаар иргэдэд зөвлөгөө өгч, сургалт сурталчилгаа хийх	Зөвлөгөө өгсөн, хүний тоо	Г
	Нөхөн үржихүйн дараах насны эмэгтэйчүүд, үргүйдэлтэй гэр бүлд анхан шатны тусламж үзүүлж,	Зөвлөгөө өгсөн хүний тоо	Т,Г

	чиглүүлэх зөвлөгөө өгч эмчид илгээх		
	Өсвөр үе болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн үржихүйн ба бэлгийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээнд тохирсон зөвлөгөө өгч, ээлтэй тусламж, үйлчилгээ үзүүлэх	Тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо	Т,Г Т,Г
	Эрсдэлт зан үйл, дадлыг (донтолт) илүүлэх, хүчирхийлэлд өртсөн иргэдэд сэтгэл заслын зөвлөгөө, мэдээлэл өгөх	Тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо	Т,Г
	Бэлгийн хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх	Тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний тоо	Т,Г
<p><b>4 дугаар зорилтын хүрээнд:</b></p> <p>Амь тэнссэн, яаралтай тусламж шаардагдсан осол гэмтэл, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, шинэ болон сэргэн тархаж байгаа халдварын үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;</p>	Эх барихын яаралтай тусламж шаардсан хүндрэлийг (манас таталт, цус алдалт, үжил, дайрлага, ураг орчмын шингэний бөглөрөл) эрт илрүүлж, тусламж иртэл анхны тусламжийг шуурхай үзүүлж, багаар тусламж үзүүлэхэд оролцох	Эх барихын яаралтай тусламж үзүүлсэн тоо, эхийн ноцтой хүндрэлийн тоо	Г
	Амь тэнссэн, яаралтай, онцгой, тохиолдолд эмнэлгийн нэн шаардлагатай тусламжийг (гэнэтийн өвчин, осол гэмтлийн үед ухаан алдсан, таталттай, амьсгал боогдсон, хаагдсан, зүрхний үйл ажиллагаа зогсох аюул тулгарсан үед) үзүүлж, дараагийн тусламж үйлчилгээг шуурхай зохион байгуулах	Амь тэнссэн, яаралтай, онцгой тохиолдолд тусламж үзүүлсэн тоо	Г
	Халдварт өвчний цар тахал, гамшиг тохиолдсон үед нөхөн үржихүй, эсэн мэнд амаржихуйн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлж бэлэн байдлыг хангах	Мэргэжлийн тусламж үзүүлсэн тохиолдлын тоо	Т,Г
	Гамшиг, онцгой байдлын үед бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэн шаардлагатай багцыг хэрэглэхэд дэмжлэг үзүүлж ажиллах;	Хэрэгжилтийн хувь	Т,Г
	Гамшиг, осол, онцгой тохиолдолд шууд харьяалагдах болон дээд албан тушаалтны шийдвэрээр	Хэрэгжилтийн хувь	Т,Г

	өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу хамтарч ажиллах		
	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой, анхан шатны бүртгэл маягыг бүрэн хөтлөх;	Ажлын тайлан	Г
<b>5 дугаар зорилтын хүрээнд:</b>  Мэдлэг, мэргэшил, ур чадвараа тогтмол дээшлүүлэх, судалгааны ажил хийх, мэргэжлийн чиглэлээр эрүүл мэндийн ажилтнуудад сургалт явуулах, анхан шатны бүртгэл маягыг хөтлөх.	Зэрэг, цолтой туршлагатай эх баригч нь шинэ эх баригчдыг шавилан сургах	Шавилан сургасан эх баригчийн тоо	Г,Х
	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдах, эх нярайд үзүүлэх яаралтай тусламжийн сургалтад хамрагдсан байх	Гэрчилгээ	Г
	Эрдэм, шинжилгээ судалгааны ажил хийх, онол, практикийн хуралд оролцох, хэвлэн нийтлүүлэх;	Илтгэл, өгүүлэл, хурлын тоо	Г,Х
	Гадаад хэл, компьютерын хэрэглээний мэдлэгээ дээшлүүлж ажиллах;	Гэрчилгээ	Г
	Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаанд манлайлан оролцох.	Нийгэмлэгийн гишүүнчлэл, Ажлын тайлан	Г,Х
<b>6 дугаар зорилтын хүрээнд:</b>  Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж, эх барихуйн тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагаанд оролцох	Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын зорилтыг хангаж ажиллах	Аюулгүй байдлыг хангаж ажилласан тоо	Т, Г
	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдол, эрсдлээс урьдчилан сэргийлэх, мэдээлэх, залруулах арга хэмжээнд оролцож ажиллах	Урьдчилан сэргийлсэн тоо Мэдээлсэн тохиолдол, эрсдлийн тоо	Г, Т
	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах, сайжруулах үйл ажиллагаанд оролцох, тасралтгүй сургалтанд хамрагдах	Хамрагдсан үйл ажиллагааны тоо	Т, Г
	Эх барихуйн тусламж үйлчилгээнд сайн туршлага, шинэ инноваци нэвтрүүлж хөгжүүлж ажиллах	Сайн туршлага, шинэ технологийн тоо	Т, Г
<b>7 дугаар зорилтын хүрээнд:</b>  Бусад үйл ажиллагаанд оролцох	Байгууллага, хамт олноос зохион байгуулсан олон нийтийн үйл ажиллагаанд оролцох	Үйл ажиллагаанд оролцсон ажлын тоо	Г
	Эмнэлгийн тоног төхөөрөмж, байгууллагын эд хогшилд ариг гамтай хандаж, хүлээлцэж, өмч хөрөнгийг зөв зохистой ашиглах эвдрэл гэмтэл үүссэн тохиолдолд холбогдох эмнэлгийн ажилтантай	Тохиолдлын тоо	Г

	холбогдож мэдээллэх, тэмдэглэл хөтлөх		
	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, баримт бичгийн нууцыг хадгалж ажиллах,	Тохиолдлын тоо	Г
	Байгууллагын удирдлага, албад, тасгийн эрхлэгч, арга зүйч нарын өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж ажиллах	Хэрэгжилтийн хувь	Г
	Авлигаас ангид байж, Авлигын эсрэг хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажиллах	Хэрэгжилтийн хувь	Г

<b>III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА</b>			
<b>Боловсрол</b>	Диплом/бакалавр		
<b>Мэргэжил</b>	Эх баригч		
<b>Мэргэшил</b>	Төгсөлтийн дараах эх баригчийн мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх		
<b>Туршлага</b>	Мэргэжлийн зэрэг хамгаалсан байх		
<b>Ур чадвар</b>	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- Албан хэрэгцээнд шаардагдах өгөгдлийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, санал, зөвлөмж боловсруулах</li> <li>- Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах</li> </ul>	
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Тулгамдсан асуудлыг хууль тогтоомж журмын хүрээнд шийдвэрлүүлэх</li> <li>- Ажлын үр дүн, үр нөлөөг урьдчилан харах</li> <li>- Мэргэжлийн зөвлөгөө өгөх</li> <li>- Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачлагатай, хариуцлагатай ажиллах</li> <li>- Хувь хүний нууц хадгалах</li> </ul>	
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн мэдлэг, туршлага, ур чадвар, мэдээллийн баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах</li> <li>- Багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх</li> <li>- Байгууллагын зорилго, үйл ажиллагаанд нийцүүлж, үр бүтээмжтэй ажиллах</li> <li>- Хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмжих</li> <li>- Төрийн албан хаагч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цагийг чанд баримтлан харилцааны соёлыг эрхэмлэх</li> </ul>	
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- Хувийн зохион байгуулалттай ажиллах</li> <li>- Англи хэлний зохих мэдлэгтэй байх</li> <li>- Жил тутам 3 ба түүнээс дээш багц цагийн сургалтад хамрагдах</li> <li>- Оффисын хэрэглээний программ дээр ажиллах</li> <li>- Дотоод сүлжээ интернетийн орчинд ажиллах</li> </ul>	

<b>IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ</b>	
<b>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</b>	
<ol style="list-style-type: none"> <li>1. Сувилахуйн албаны дарга</li> <li>2. Сувилахуйн арга зүйч</li> <li>3. Тасгийн ахлах эх баригч</li> </ol>	
<b>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо</b>	<b>Бусад харилцах субъект</b>
<ul style="list-style-type: none"> <li>- Сувилагчийн туслах</li> <li>- Үйлчлэгч</li> </ul>	<ol style="list-style-type: none"> <li>1. Эмнэл зүйн тасгууд</li> <li>2. Үйлчлүүлэгч түүний асран хамгаалагч, ар гэрийхэн.</li> <li>3. Мэргэжлийн нийгэмлэг холбоо</li> </ol>
<b>V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ</b>	
<b>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</b>	<b>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</b>
<u>Албан тушаал:</u> <b>ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ ДАРГА</b> .....А.ОТГОН (Гарын үсэг)            (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20... оны ... дугаар сарын ... -ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> <b>ОРХОН АЙМГИЙН БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ</b> <u>Шийдвэрийн огноо:</u> ..... <u>Дугаар:</u> .....
<b>АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН</b>	
<u>Байгууллагын нэр :</u> <b>БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ</b> .....Ц.НАРАН-ЭРДЭНЭ (тамга/тэмдэг)	<u>Тасгийн нэр :</u> (Гарын үсэг)            (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20... оны ... дугаар сарын ... -ны өдөр
<b>АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТТОЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН</b>	
<b>ТАСГИЙН ЭХ БАРИГЧ</b>	
20... оны ... дугаар сарын ... -ны өдөр	